



ЗАВХАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
БИЧМЭЛ ТАЙЛАН

ЗАВХАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2026 ОНЫ
ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ
ТАЙЛАНГИЙН АГУУЛГА

1. Нэгжийн чиг үүрэг, бодлогын баримт бичгийн талаар
 - 1.1 Удирдлага зохион байгуулалт
 - 1.2 Хүний нөөцийн талаар
 - 1.3 Иргэний улсын бүртгэл
 - 1.4 Хуулийн этгээдийн улсын бүртгэл
 - 1.5 Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл
 - 1.6 Хяналтын улсын байцаагчийн үйл ажиллагаа
 - 1.7 Архивын үйл ажиллагаа
2. Төлөвлөгөө, үүрэг даалгаврын хэрэгжилт
 - 2.1 Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаас өгсөн үүрэг, даалгавар, тушаалын хэрэгжилт
3. Санхүүгийн үйл ажиллагаа
 - 3.1 Санхүү, үнэт цаасны тооцоо, тайлан мэдээ
4. Мэдээллийн технологийн чиглэлээр
 - 4.1 Ил тод байдал
5. Бусад
 - 5.1 Бусад байгууллагатай хамтран ажилласан тухай

НЭГ: НЭГЖИЙН ЧИГ ҮҮРЭГ, БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЛААР

1.1 УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

2026 онд Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний зорилтын дагуу Монгол улсын үндсэн хууль, Улсын бүртгэлийн ерөнхий хууль, Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Кибер аюулгүй байдлын тухай хууль, Гэр бүлийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмуудыг хэрэгжүүлэн иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг эхний хагас жилийн байдлаар 4155 иргэнд үзүүлж, иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2894, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 2493, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 714, лавлагаа мэдээлэл улсын бүртгэгчээс 1716, улсын бүртгэлийн дөт киоск машинаас 2133 иргэнд нийт 11211 иргэн, хуулийн этгээдэд улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай чанартай хүргэн ажиллалаа.

1.2 ХҮНИЙ НӨӨЦИЙН ТАЛААР

Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн А/157 тоот тушаалаар батлагдсан орон тооны дагуу 2026 онд Улсын бүртгэлийн хэлтсийн дарга 1, захиргааны ахлах мэргэжилтэн 1, хяналтын улсын байцаагч 1, тасгийн дарга бөгөөд улсын ахлах бүртгэгч 2, хуулийн этгээдийн улсын бүртгэгч 1, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 4, иргэний улсын бүртгэлийн тасгийн улсын бүртгэгч 2, ерөнхий нягтлан бодогч 1, мэдээллийн технологийн ажилтан 1, архивч 2, Архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав 1, сумдын улсын бүртгэгч 24, гэрээт ажилтан 3 нийт 44 ажилтан, албан хаагчтайгаар улсын бүртгэлийн үйлчилгээг иргэн хуулийн этгээдэд хүргэн ажиллаж байна. 2026 онд Завханмандал суманд сул орон тоотой ажиллаж байна.

1.3 ИРГЭНИЙ УЛСЫН БҮРТГЭЛ

Иргэний улсын бүртгэлийн үйлчилгээг 2026 оны эхний хагас жилийн байдлаар 4155 иргэнд үзүүлсэн байна. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 2894 бүртгэлийн 4895 нотлох баримтыг цахимжуулж, хянан мэдээллийн санд баталгаажуулсан байна. Тоон гарын үсгийг 2026 оны эхний хагас жилийн байдлаар улсын бүртгэгчээс өссөн дүнгээр 28429 иргэнд олгосон.

Улсын бүртгэлийн мэдээллийн санд регистрийн дугаар буруу, овог, нэр, үсгийн зөрүүтэй иргэдийн зөрчлийг тухай бүр арилгаж хяналтын улсын байцаагчийн 4 дүгнэлт гаргуулж ИУБ-11, ИУБ-15, ИУБ-16 маягтуудыг тус тус нөхөн бичиж мэдээллийн санд оруулсан. Мэдээллийн санд үсгийн алдаатай болон мэдээлэл буруу орсон 572 иргэний мэдээллийг нэгдсэн дүгнэлтүүдээр засварлан ажиллаж байна.

Иргэнд улсын бүртгэлийн дөт киоск машинаар 2133, улсын бүртгэгч нараас 1261 лавлагаа, албан хэрэгцээнд 617, албан тоотоор 380 лавлагааг өгч ажилласан байна. 2026 оны 05 дугаар сарын байдлаар нийт 17 албан бичгийг Улсын бүртгэлийн ерөнхий газрын Иргэний улсын бүртгэлийн газарт хүргүүлэн ажилласан байна.

ҮНДЭСНИЙ ЭНГИЙН ГАДААД ПАСПОРТ ОЛГОЛТЫН ТАЛААР 2024 он, 2025 он, 2026 оны эхний хагас жилд олгосон гадаад паспортын үйлчилгээг харьцуулсан үзүүлэлт

Д/д	Он	Гадаад паспорт / шинэ /	Хил зорчих олон удаагийн үнэмлэх	Хил зорчих нэг удаагийн үнэмлэх
1	2024 он	2839	0	801
2	2025 он	2298	0	661
3	2026 он хагас жил	668	0	0

1.4 ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛ

Тайлант хугацаанд Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн ажил, үйлчилгээг удирдлагаас өгсөн үүрэг даалгавар, чиглэлийг бүрэн хэрэгжүүлж 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт 717 иргэн, хуулийн этгээдэд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлэн ажиллаж байна.

Үүнд:

Д/д	Хуулийн этгээдийн бүртгэлийн төрөл	2024 он	2025 он	2026 он
1	Хуулийн этгээдийн нэр баталгаажуулалт	616	516	187
2	Шинээр үүсгэн байгуулсан хуулийн этгээд	578	303	75
3	Хязгаарлагдмал хариуцлагатай компани	78	82	41
4	Төрийн бус байгууллага /НҮТББ, ГҮТББ/	24	33	8
5	Нөхөрлөл	4	4	2
6	Хоршоо	465	177	20
7	Үйлдвэрчний эвлэлийн байгууллага	0	4	4
8	Сан	2	0	0
9	Төрийн байгууллага, албан газар	1	3	0
10	Хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт	191	249	174
11	Хуулийн этгээдийн бүртгэлийн лавлагаа олгосон	247	167	56
12	Хуулийн этгээд татан буулгасан бүртгэл	0	4	1
13	Бусад бүртгэл /тамга тэмдэг, хуулбар, улсын бүртгэлээс хасахтай холбоотой хүсэлт/	50	170	148
	Нийт	1692	1409	714

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн 8.3 т заасны дагуу аймагт үйл ажиллагаа явуулах хуулийн этгээдийн салбарыг бүртгэсэн.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2018 оны А/216 тоот тушаалаар батлагдсан “Тамга, тэмдэг хийлгэх үйл ажиллагаанд хяналт тавих, лавлагаа олгох журам”-ын дагуу Хуулийн этгээдийн тамга, тэмдгийн хяналтын хуудас 96 олгож, хуулийн этгээдийн 23 тамга, тэмдгийг хураан авч хүчингүй болгосон.

Тайлангийн хугацаанд шинээр байгуулагдсан 75 хуулийн этгээд, 174 хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлт, 5 лавлагаа, эх нотлох баримт бичиг хураан авсан тамга тэмдгийг

журмын дагуу архивд хүлээлгэн өгч, цаасан баримтыг цахим хэлбэрт шилжүүлэн ажилласан байна.

1.5. ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХҮРЭЭНД

Тайлант хугацаанд нийт 2583 мэдүүлэг хүлээн авч эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журам, чиглэлд заасны дагуу 2493 бүртгэлийг хийсэн. Тосонцэнгэл, Баянтэс, Сонгино, Цагаанхайрхан, Их-Уул, Нөмрөг, Тэлмэн, Цагаанчулуут, Сантмаргац, Тэс, Цэцэн-Уул сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг үзүүлж тухайн сумдад тайлант хугацаанд нийт 742 бүртгэлийн үйлчилгээг үзүүлсэн нь нийт бүртгэлийн 29.7 хувийг эзэлж байна.

Тайлант хугацаанд нийт 737 гэрчилгээ бичиж олгосноос 387 үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн, 350 газар өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээг тус тус бичигдсэн байна.

Засгийн газрын 2020 оны 230 дугаар тогтоолын дагуу байгууллагад үйлчилгээний хураамжаас 63.184.69 төгрөг орон нутгийн төсөвт тэмдэгтийн хураамжаас 1.1618.494 төгрөг, үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсны албан татвараас 128.667.324 төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Нийт хүлээж авсан 2493 мэдүүлгийг цахим мэдээллийн сан болох Electronic Property Registration System (ePRS)-т шивж оруулсан бөгөөд газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 117 хувийн хэрэг, газар өмчлөх эрхийн 110 хувийн хэрэг шинээр нээж, 11 хувийн хэрэг хааж, 2266 бүртгэлийн хувийн хэрэгт баяжилт үйлчилгээ хийсэн.

Тайлант хугацаанд хуулийн этгээдийн хүсэлтийн дагуу хяналтын байгууллагаас ирсэн 28 тоотын дагуу 30 иргэний лавлагаа мэдээллийг холбогдох хууль журмын дагуу гаргасан. Эрх бүхий этгээдийн шийдвэрээр 13 эд хөрөнгийн захиран зарцуулах эрхийг түдгэлзүүлсэн, 7 эд хөрөнгийн эрхийн захиран зарцуулах эрхийн сэргээсэн, Хяналтын улсын байцаагчийн 2026 оны 03 дугаар сарын 24-ны өдрийн 1125 дугаартай дүгнэлтийг үндэслэн 7 хувийн хэрэгт завсар өөрчлөлт хийсэн.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль болон бусад холбогдох хууль, журам, чиглэлд заасны дагуу эд хөрөнгийн бүртгэлийн тоо мэдээг 5 удаа, Улсын бүртгэлийн 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 5/9854 дугаар “Мэдээний маягт хүргүүлэх тухай”-ын хүрээнд тайланг заасан маягт загварын дагуу 5 удаа, Үнэт цаасны мэдээг 5 удаа гарган холбогдох газарт нь хүргүүлсэн.

Хоёр. Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын чиглэл, зөвлөмж, үүрэг даалгаврын хүрээнд

Энэ хугацаанд Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газраас ирүүлсэн тушаал, чиглэл, зөвлөмж, санал авах тухай тайлан ирүүлэх тухай, хугацаатай үүрэг даалгаврыг цаг тухай бүрт нь Улсын бүртгэгч нарт танилцуулан хүргүүлэн дотоод сүлжээ болох 100 дотор байршуулан сумдын Улсын бүртгэгч нарт онлайнаар 7 хоног бүрийн лхагва гаригт мэдлэг хуваалцах өдөр нэртэй цахим уулзалтыг зохион байгуулан ажиллаж байна.

1.6. ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

2026 оны эхний хагас жилийн байдлаар Иргэний улсын бүртгэлийн зөрчил арилгах хяналтын улсын байцаагчийн 12 дүгнэлт гарган, 449 бүртгэлд хяналт тавьж, 9 зөрчил илрүүлэн зөрчлийг шалгалтын явцад шийдвэрлэсэн. Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 30 бүртгэлд хяналт тавьж, 1 зөрчил илрүүлэн шийдвэрлэсэн. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн зөрчлийг арилгах хяналтын улсын байцаагчийн 8 дүгнэлт гарган, 171 бүртгэлд хяналт тавьж, 5 зөрчлийг илрүүлэн шийдвэрлэсэн. Улсын бүртгэлийн архивын чиглэлээр 20 архивын нэгжид, 44 архивын лавлагаанд хяналт тавин ажилласан.

Хагас жилийн байдлаар 449 бүртгэлд цахимаар хяналт тавин, зөрчилтэй 9 бүртгэлийн зөрчлийг арилгах хяналтын улсын байцаагчийн дүгнэлт гарган ажиллаж байна.

2026 оны 05 сарын байдлаар Иргэний улсын бүртгэлтэй холбоотой 4, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой 8, зөрчлийн талаарх 56 гомдол мэдээллийг нийт 68 өргөдөл, гомдлыг хүлээн авч хуулийн хугацаанд шалган шийдвэрлэсэн байна.

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.20-д заасан зөрчилд улсын бүртгэлийн хяналтын улсын байцаагч шалган шийдвэрлэхээр заасны дагуу 54 иргэн, 1 хуулийн этгээдэд зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 1.580.000 төгрөгийн торгох шийтгэл оногдуулан ажилласан байна.

Зөрчлийн шинжтэй гомдол мэдээллийн бүртгэлийг 5 удаа хянуулан, зөрчил шалган шийдвэрлэсэн материалыг 2 удаа аймгийн Прокурорын газарт шалгуулан ажиллаж байна.

Хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөний дагуу иргэний улсын бүртгэл, хуулийн этгээдийн улсын бүртгэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд 2 удаа хяналт шалгалт хийж дүнг илтгэх хуудсаар Хэлтсийн даргад танилцуулан УБЕГ-ын Хяналт шалгалтын газарт хүргүүлэн ажиллаж байна.

1.7 .АРХИВЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Архивд хадгалагдаж байгаа баримтыг эмхлэн цэгцлэх ,архивын баримт хүлээн авах, данс тоо бүртгэлийн баримт бичгүүдийг хөтлөх, санд байрлуулах, баримтыг ангилах, төрөлжүүлэх, горимын дагуу хадгалах, хамгаалах, аюулгүй байдлыг хангах архив зүйн бусад ажлыг хийж гүйцэтгэнэ.

ИРГЭНИЙ БАРИМТЫН АРХИВ

Шинээр бүртгэл хийгдсэн ИУБ11-280, ИУБ12-5,ИУБ13-9, ИУБ14-8, ИУБ15-66, ИУБ16-13, ИУБ18-151, ИУБ31-863 нийт 1395 маягтыг хүлээн авч хувийн хэрэгт байршуулан баяжилт хийсэн.

16 насанд хүрч иргэний үнэмлэх авсан 445 иргэний ХААТР-11 маягтыг хүүхдийн сангаас түүвэрлэн авч ИУБ-31 маягтын хамт хувийн хэргийн санд байршуулан баяжилт хийж ажилласан. 151 иргэний ИУБ-18 маягтыг тухайн хувийн хэргийн хамт түүвэрлэн нас баралтын санд байршуулсан.

Үндсэн үйл ажиллагааны чиглэлээр бүртгэл хийгдсэн сумдын 21 хадгаламжийн нэгж 363 хуудас, бүртгэлийн бүрдүүлсэн баримт 31 хадгаламжийн нэгж 4315 хуудас, түр хадгалах 78 хадгаламжийн нэгж 9011 хуудас, гадаад паспорт олголтын 31 хадгаламжийн нэгж 7371 хуудас, хяналтын байцаагчийн дүгнэлт 1 хадгаламжийн нэгж 81 хуудас бүхий хадгаламжийн нэгжийг

бүртгэгч нараас хүлээн авч тэмдэглэл хөтлөн архивын санд бүртгэл тус бүрээр ялган байршуулсан.

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэхтэй холбоотой 341 иргэний ХААТР-11, 12, 13 маягтыг цахимжуулан ажилласан

Хувийн хэргийн санд тооллого хийж нийт 55310 хувийн хэрэг 218262 маягтыг тоолж гадна хайрцгийг сольж тоо бүртгэл хөтлөн тооллогын явц 98% тай ажиллаж байна. Архивын өрөөний аюулгүй ажиллагааг ханган гал унтраах анхан шатны хэрэгсэл болох галын хор, ууттай элс, хүрзийг бэлэн байдалд байлгаж байна. Галын хорыг сард нэг удаа шалган тэмдэглэн, чийгшилтийг стандартын дагуу бүртгэл хөтлөн ажиллаж байна.

Архивын хадгаламжийн санд тоос шороо үүсэх, мэрэгч амьтад болох хортон шавж бий болох, баримт ялзарч хөгцрөхөөс хамгаалахын тулд ариун цэвэр эрүүл ахуйн дэглэмийг сахин ажиллаж байна.

ХУУЛИЙН ЭТГЭЭД, ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН АРХИВ

Тайлан хугацаанд Хуулийн этгээдийн бүртгэлийн шинээр үүсгэн байгуулагдсан 35 бүртгэл, өөрчлөлтийн 81 бүртгэлийг улсын бүртгэгчдээс хүлээн авч архивын журмын дагуу архивд байршуулан ажиллалаа.

Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивд 2026 оны эхний хагас жилийн байдлаар газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 110 хувийн хэрэг, газар өмчлөх эрхийн 83 хувийн хэрэг шинээр нээгдсэн хувийн хэргийг улсын бүртгэгчдээс хүлээн авч хадгаламжийн санд зааврын дагуу байршуулж хувийн хэрэгт холбогдох баяжилт үйлчилгээг хийж улсын бүртгэгчдээс гарсан нотлох баримтуудыг бүртгэлийн дэвтэрт бүртгэж нь хувийн хэрэгт тухай бүрд нь байршуулан ажиллаж байна. Тайлант хугацаанд эд хөрөнгийн эрхийг бүртгэлийн 804 хувийн хэрэгт үйлчилгээ орсон бөгөөд улсын бүртгэгч тус бүрээр нь бүртгэлийн А-2 маягтад тэмдэглэл хөтлөн архивд байршуулан баяжилт хийсэн. Улсын бүртгэлийн хэлтсийн Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн систем сүлжээгүй байх үед 58 хувийн хэргийн дугаарлалт, үйлчилгээний дугаарлалт хувийн хэргийг татаж улсын бүртгэгчдэд дугаар болон үйлчилгээг харж өгч ажиллаж байна. Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн архивын 620 хувийн хэргийн хавтсыг шинээр сольж ажиллалаа. Архивын ерөнхий газрын 2025 оны А/14 дүгээр тушаалаар баталсан “Төрийн архивын баримтад нэгдсэн тооллого явуулах тухай” журмын дагуу Хэлтсийн даргын 2026 оны 05 сарын 20-ны өдрийн А/11 дугаар тушаалын дагуу ажлын хэсэг байгуулж Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивыг холбогдох журмын дагуу тоолж улсын бүртгэгчдэд хувийн хэргийг холбогдох жагсаалтын дагуу архиваас гарган өгч, тоолсон хувийн хэргийг улсын бүртгэлийн дугаарын дагуу буцаан байршуулан тооллогын ажил 45 %-тай үргэлжилж байна.

Эд хөрөнгийн эрхийн архивд газраас бусад үл хөдлөх хөрөнгийн 9937, газрын 8086, Хуулийн этгээдийн бүртгэлийн 3727 хувийн хэрэг тус тус хадгалагдаж байна.

ХОЁР: ТӨЛӨВЛӨГӨӨ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ

2.1 УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ, ДААЛГАВАР, ТУШААЛЫН ХЭРЭГЖИЛТ

2026 оны хагас жилийн байдлаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 3 удаагийн шуурхай хурлаас өгсөн үүрэг даалгавар бусад үүрэг даалгавар, албан даалгаврын биелэлтийг улирал, хагас жилээр гарган холбогдох газруудад хүргүүлэн ажиллалаа.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын Улсын бүртгэгч томилж, чөлөөлсөн 8 тушаал, Төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв олгох тухай 1 тушаал, Хяналт шалгалтын газраас 2, аймгийн прокурорын газраас 2, Иргэний улсын бүртгэлийн 6, Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхий улсын бүртгэлийн 10 чиглэл, зөвлөмж, хугацаатай үүрэг даалгаврыг цаг тухай бүрд нь Улсын бүртгэгч нарт бүрэн танилцуулан танилцах хуудсанд гарын үсэг зуруулан, сумдын улсын бүртгэгч нарт цахимаар тогтмол танилцуулан ажиллаж байна.

ГУРАВ: САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

3.1 САНХҮҮ, ҮНЭТ ЦААСНЫ ТООЦОО, ТАЙЛАН МЭДЭЭ

Улсын төсвөөс 835.3 сая төгрөгийн санхүүжилт авч Цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлд 706.2 сая, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 28.6 сая, ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхтэй холбоотой урамшуулал тусламж дэмжлэгт 18.5 сая, бусад бараа үйлчилгээний зардалд 11.6 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Улсын бүртгэлийн ерөнхий газрын Санхүү, аж ахуйн хэлтэст төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, тайланг сар бүрийн 2-ны дотор 5 удаа, улирлын тайлангуудыг холбогдох тодруулгын хамт хуулийн хугацаанд хүргүүлэн ажилласан.

2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2025 оны 02 дугаар сарын 13-ны өдөр Төрийн аудитаар хянуулж “Зөрчилгүй” дүгнэлтээр үнэлэгдсэн болно.

2026 оны эхний хагас жилийн байдлаар Улсын бүртгэлийн үйлчилгээний орлогоос 35.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 84.1 сая төгрөгийг Улсын төсвийн 170000075756 тоот дансаар дамжуулан төвлөрүүлж 136.9 хувиар давуулан биелүүлж ажиллалаа.

Бараа материал, үндсэн хөрөнгө:

Иргэний улсын бүртгэлийн 21 төрөл, Эд хөрөнгийн улсын бүртгэлийн 3 төрөл, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 3 нийт 27 төрлийн үнэт цаас ашиглагдаж байгааг Улсын бүртгэлийн ерөнхий газраас хөрөнгийн санхүүжилтээр 4 удаагийн татан авалт хийж нөөцийг бүрэн ханган ажиллаж байна. Хэлтэс шинэ байранд орсонтой холбоотой цэвэрлэгээ, засвар үйлчилгээний зардал нэмэгдсэн боловч батлагдсан төсөвтөө багтаан зарцуулалт хийж ямар нэгэн өр, авлагагүй ажилласан.

Тайлант хугацаанд сумдын Улсын бүртгэгчид болон албан хаагчдад олгосон үнэт цаас, хаатр маягт, бичиг хэргийн материалуудыг зохих журмын дагуу шаардах хуудас бичүүлж, агуулахын бүртгэлийн дэвтэр хөтөлж, өгсөн үнэт цаасны хатуу дугаарыг онлайн программд хуваарилан ажиллаж байна.

Тус хэлтэст Улсын бүртгэлийн ерөнхий газраас 2026 онд Суурин компьютер 2, Зөөврийн компьютер 1, Принтер 2 ширхгийг тус тус шинээр өгч үйл ажиллагаандаа ашиглаж байна

ДӨРӨВ: МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИЙН ТАЛААР

Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээллийн технологийн ажилтан нь Монгол улсын Засгийн газраас баталсан “Мэдээлэл, сүлжээний аюулгүй байдлыг хангах” журам ,“Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам”-ыг удирдлага болгон дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Цахим хуудаст байгууллагын үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг цаг тухай бүрд нь байршуулсан. Эхний хагас жилийн байдлаар www.Zavkhan.burtgel.gov.mn, цаг үе,үйл явдлын талаарх мэдээ иргэд, аж ахуй нэгжүүдэд заавар зөвлөгөө өгсөн талаар бичлэг 35-г мөн [Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс facebook page-д](#) 66 мэдээ мэдээллийг байршуулан ажиллаж байна.Төрийн байгууллагын албан ёсны цахим хуудас болох <https://www.gov.mn/org/> хаяг шинэчлэгдсэнтэй холбогдуулан өөрийн байгууллагын цахим хаяг болох <https://www.gov.mn/org/zavkhan-burtgel> сайтыг хөгжүүлэн холбогдох хууль, дүрэм журам үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг хөгжүүлэн ажиллаж байна.

Хэлтсийн албан хаагчдын сүлжээ компьютер, тоног төхөөрөмжүүдийн эвдрэл гэмтэл гарсан үед цаг алдалгүй засварлаж хэвийн ажиллагаанд оруулан ажиллаж байна. Эхний хагас жилийн байдлаар 13 удаагийн засвар үйлчилгээ үзүүлсэн байна.

Байгууллагын дотоод сүлжээний ажиллах хэвийн байдлыг бүрдүүлэн сүлжээнд алдаа гарах, тасрах гэх мэт техникийн саатлуудыг тухай бүрд нь холбогдох арга хэмжээг аван засварлан ажиллаж байна.

Улсын бүртгэлийн ерөнхий газраас цахим видео хурал болон цахим сургалт хурлыг тухай бүрд нь холбон техник тоног, төхөөрөмжийг хэвийн ажиллуулсан байна. Завхан аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс нь сумдын улсын бүртгэгч нарт цахим видео хурал болон сургалтыг иргэний улсын бүртгэлийн талаар 4, захиргааны ахлах мэргэжилтэн 5, хуулийн этгээд эд хөрөнгийн тасаг 10 цахим хурал зохион хийж холбогдох линк үүсгэх ажлыг хийж гүйцэтгэлээ.

Байгууллагын сүлжээний аюулгүй байдал, гадна халдлага, мэдээлэл алдагдахаас сэргийлэн арга хэмжээ авч ажиллан Улсын бүртгэлийн ерөнхий газраас өгсөн заавар зөвлөмжийн дагуу сүлжээний хамгаалалтыг сайжруулж тохиргоог хийлгэн ажиллаж байна.

Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, ЗГ-ын 2013 оны 411 дүгээр тогтоолоор батлагдсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам“ Хууль зүйн сайдын 2012 оны А/15 дугаар тушаалаар батлагдсан “Хууль зүйн салбарын Нээлттэй бодлогын баримт бичиг” Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлтээр тогтоосон. Ил тод нээлттэй байдлыг мэдээллийн цахим хуудсанд бүрэн байршуулж, олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.

Иргэдийн мэдээлэл хайх, мэдээлэл хүлээн авах эрхийг хангах, ажлын хүрээнд <https://frontoffice-dev.shilen.gov.mn/index> 5 чиглэлийн 87 мэдээллийг байршуулан ажиллаж 2026 оны нэгдүгээр улиралд 86.86% А үнэлэгдэж 2026 оны 2-р улирлын тайланг хуулийн хугацаанд нь 06 дугаар сарын 31-ны дотор илгээхээр бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Хэлтсийн мэдээллийн ил тод байдлын самбарт Улсын бүртгэлийн хууль тогтоомж тушаал шийдвэр төсөв санхүү, статистик тоо мэдээ, бараа материал худалдан авалтын мэдээллийг сар бүр байршуулдаг мөн хэлтсийн вэб сайт шилэн данстай холбон мэдээллийг тухай бүр байршуулан ажиллаж байна.

Байгууллагын хийж гүйцэтгэсэн ажил, иргэдэд мэдээлэх шаардлагатай мэдээг цаг тухай бүрд нь байршуулсан ба байгууллагын фэйсбүүк цахим хуудас болох <https://www.facebook.com/profile.php?id=61557303519406> хуудсанд жилийн эцсийн байдлаар 66 мэдээ мэдээлэл, видео тавигдсан байна.

Өргөдөл, гомдол хүлээн авах хариуцсан албан хаагчийн албан тушаал, овог нэр, харилцах утасны дугаар тодорхой бичиж хэлтсийн албан ёсны сайт болох дараах сайтуудад www.Zavkhan.burtgel.gov.mn, <https://www.gov.mn/mn/organization/zavkhanubh> 35-г байршуулан ажиллаж байна.

ТАВ: БУСАД

5.1 БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАМТРАН АЖИЛЛАСАН ТУХАЙ, ИДЭВХИ САНААЧЛАГА ШИНЭЛЭГ АЖИЛ

Улсын бүртгэлийн хэлтэс нь Төрийн бодлого, хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлж, иргэдэд чиглэсэн үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэн, хариуцлага, ил тод байдал, ажлын үр дүнгээрээ 2025 оны үйл ажиллагааны үнэлгээгээр "ТЭРГҮҮН БАЙР" эзэлж "ШИЛДЭГ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА"-аар шалгарлаа.

"Авлигын эсрэг хууль", "Авлига, албан тушаалын гэмт хэрэг"-ээс урьдчилан сэргийлэх, Эрүүгийн хуулийн тусгай ангийн 22 дугаар бүлэг Авлигын гэмт хэргийн талаар мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх зорилгоор Завхан аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүхийн Зохион байгуулалтын хэлтсийн дарга С.Оюунтунгалаг, шүүгчийн туслах О.Түвшинжаргал, Д.Бямбабаяр нар сургалт мэдээлэл өгч ажиллалаа.

Завхан аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газартай хамтран 4 хүмүүжигчид зөөврийн тоног төхөөрөмж ашиглан цахим иргэний үнэмлэхийн хугацаа дууссан нэг иргэний 25 насны сунгалтыг хийж 3 иргэнд иргэний цахим үнэмлэх дээр "ТООН ГАРЫН ҮСЭГ" олгож "И-монгол" цахим системд орсон Улсын бүртгэлийн үйлчилгээний талаар зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

"Залилах гэмт хэргийн нөхцөл байдал төрөл хэлбэр, урьдчилан сэргийлэх зөвлөмж" чиглэлээр Завхан аймгийн цагдаагийн газрын Гэр бүл, хүүхэд, урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн Цагдаагийн хошууч П.Даваахүү сургалт хийж албан хаагчид бүрэн хамрагдлаа. Сургалтаар Залилах гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, түгээмэл хэлбэрүүдийг танин мэдэх, урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг нэмэгдүүлэв.

Орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 105 жилийн ой, ТЕГ-ын Завхан аймаг дахь хэлтсийн 100 жилийн ой, Хилийн цэргийн 0277 ангийн Арцсуурийн заставын 50 жилийн ой МОНГОЛ ЦЭРГИЙН ӨДӨР"-ийг тохиолдуулан Завхан аймаг дахь Төрийн цэргийн болон Хууль сахиулах байгууллагууды албаны бэлэн байдлыг хангах, байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх зорилготой спортын цогцолбор тэмцээн 03 дугаар сарын 09, 10-ны өдрүүдэд зохион

байгуулагдаж спортын тэмцээнд 16 байгууллагын 500 гаруй тамирчид оролцов.

Улиастай сумын төрийн байгууллага, аж ахуйн нэгж нийт ард иргэдийн "Цасны баяр-2026" арга хэмжээ болж хэлтсийн албан хаагчид оролцов.

УИХ-ын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Б.Энхбаяр, Бодлогын хэрэг зохицуулалтын газрын дарга П.Оростогоо, Санхүү хөрөнгө оруулалтын газрын дарга Д.Гантуяа нар Завхан аймагт ажиллаж иргэд, төрийн алба хаагчидтай уулзалт хийж, салбарын бодлого шийдвэрийн талаар мэдээлэл өгч албан хаагчид бүрэн хамрагдав.

Уулзалтын үеэр улсын бүртгэлийн хэлтсийн 3 албан хаагчид Хууль зүйн яамны шагналаар шагнав. Мөн Улсын бүртгэлийн хэлтэст автомашин газар дээр нь шийдвэрлэж ажиллалаа.

Аймгийн засаг даргын тамгын газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын газар, Боловсролын газар, Цагдаагийн газрын хамтарсан “Эцэг эхийн хурал” арга хэмжээ 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулагдаж тус арга хэмжээнд хэлтсийн эцэг эхийн зөвлөлийн гишүүд оролцож сургалт мэдээлэлд хамрагдсан.

Арга хэмжээнд Хүүхэд, гэр бүл хөгжил хамгааллын газрын дарга Б.Баярсайхан “Хүүхэд-хайр-ирээдүй” сэдвээр, ЦЕГ-ын Урьдчилан сэргийлэх газрын Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Д.Будзаан “Хүүхдийн эрх ба хууль” сэдвээр, Боловсролын Ерөнхий газрын Суралцагчийн хөгжлийн газрын дарга А.Халиунаа “Сургуульд суурилсан хүүхэд хамгаалал” сэдвээр, ХГБХХЕГ-ын мэргэжилтэн У.Долгормаа “Хүүхдийн аюулгүй байдал-Эцэг эхийн оролцоо” сэдвээр сургалт мэдээллийг хийсэн.

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 339, 340 дүгээр тогтоолоор батлагдсан “Гамшгийн аюулын тухай зарлан мэдээллийн дохио дамжуулах”, “Гамшгийн үед нүүлгэн шилжүүлэх журам”-ыг хэрэгжүүлэх дадлага сургуулийг орон даяар 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 16:00 цагт зохион байгуулав.

Аймгийн онцгой байдлын газраас “ГАМШГИЙН АЮУЛЫН ДОХИОГООР АЖИЛЛАХ” сургалт дадлагыг хийж тус сургалтад хэлтсийн “Гамшгаас хамгаалах мэргэжлийн бүлэг”-ийн 10 албан хаагч нэг техник хэрэгсэлтэй оролцов.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын нэгдсэн архивын газрын дарга бөгөөд ёс зүйн дэд хорооны дарга С.Оюунгэрэл болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын хяналт шалгалтын газрын хяналтын улсын ахлах байцаагч Н.Анхбаяр нарыг Завхан аймагт ажиллах хугацаанд “Ёс зүй болон ёс зүйн дэд хорооны бүтэц орон тоо, үйл ажиллагааны тайлан, хяналтын байцаагчийн хяналт болон зөрчлийн арга хэмжээ сэдвүүдээр 2 цагийн сургалт авч 16 албан хаагч танхимаар сумдын бүртгэгч нар цахимаар хамрагдлаа.

“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өнөөгийн нөхцөл байдал”, “Оффис ажлын байрны аюулгүй ажиллагаа” чиглэлээр Завхан аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газраас сургалт авч хэлтсийн албан хаагчид танхимаар /13 албан хаагч/, сумдын албан хаагчид цахимаар /18 албан хаагч/ нийт 31 албан хаагч хамрагдлаа.

Сургалтаар Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн өнөөгийн нөхцөл байдал аж ахуй нэгж байгууллагын хэрэгжүүлэх үйл ажиллагаа, оффис ажлын байрны аюулгүй ажиллагааны мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлэв

Сургалтыг Завхан аймгийн Хөдөлмөр халамж үйлчилгээний газрын Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан мэргэжилтэн Б.Болорчулуун 2026 оны 04 дугаар сарын 23-ны өдөр сургалт мэдээлэл өгч ажиллалаа.

Өөрийн биеэр ирж улсын бүртгэлийн үйлчилгээ авах боломжгүй иргэдийн хүсэлтийг цахимаар болон утсаар авах ажлыг тогтмол зохион байгуулж хүсэлт ирүүлсэн Улиастай сумын өндөр настай 2 иргэний шилжилт хөдөлгөөний бүртгэлийг, Тэс сумын тулгуур эрхтний бэрхшээлтэй /ХЧА-80%/ нэг иргэний биеийн давхцахгүй өгөгдөл /45 насны сунгалт/-ийн бүртгэлийг зөөврийн тоног төхөөрөмж ашиглан бүртгэлийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна.

ХУУЛЬЧДЫН ПРО БОНО БУЮУ "НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ" БОЛЛОО

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа байгууллагуудын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг иргэд, олон нийтэд сурталчлах, иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, байгууллагын ил тод байдлыг хангах зорилготой ХУУЛЬЧДЫН ПРО БОНО БУЮУ "НЭЭЛТТЭЙ ХААЛГАНЫ ӨДӨРЛӨГ"-ийг зохион байгуулав.

Тус өдөрлөгөөр зөврийн тоног төхөөрөмж ашиглан иргэдэд бүртгэлийн үйлчилгээг газар дээр нь үзүүлж, зөвлөгөө мэдээлэл өгөх, салбарын хууль эрх зүйг сурталчлах, гарын авлага, зөвлөмж тарааж иргэдээс сэтгэл ханамжийн судалгаа авч ажилласан. Нээлттэй хаалганы өдөрлөгөөр 37 иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлж 93 иргэн, хуулийн этгээдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажиллалаа.

- Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 15
- Эд хөрөнгийн улсын бүртгэлийн чиглэлээр 11
- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 6
- Тоон гарын үсэг 5
- Зөвлөгөө мэдээлэл өгсөн 93
- Үйлчлүүлэгчээс авах сэтгэл ханамжийн судалгаанд хамрагдсан 39

Аймгийн эрүүл мэндийн газар, хүүхдийн байгууллагын хамтарсан "Хүүхэд эрхэм хэрэглэгч аяны хүрээнд "Хүүхэд хүмүүжлийн эерэг арга", "Эрүүл зөв зохистой хооллоо" сэдэвт сургалт 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр зохион байгуулагдаж тус хэлтсийн эцэг эхийн зөвлөлийн 2 албан хаагч хамрагдлаа.

Мөн аймгийн засаг даргын тамгын газраас зохион байгуулсан "Монгол бичгээр цахим бичвэр боловсруулах арга зүй" сэдэвт танхимын сургалтад 2026 оны 04 дүгээр сарын 27, 28-ны өдрүүдэд архив, бичиг хэргийн эрхлэгч, нярав Д.Батгэрэл хамрагдсан.

"Олон улсын гэр бүлийн өдөр"-ийг тохиолдуулан 2026 оны 05 дугаар сарын 11-ний өдөр аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран 5 гэр бүлд "ГЭРЛЭЛТИЙН БАТЛАХ ГАРДУУЛАХ ЁСЛОЛ"-ийг зохион байгууллаа.

Төрийн албан хаагчдын мэдлэг, ур чадвар, хандлагыг дээшлүүлж, ил тод, хариуцлагатай, үр ашигтай төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх, шийдвэр гаргалтын чадварыг бэхжүүлэх зорилгоор Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Конрод Адейнаурын Сан, аймгийн Засаг даргын тамгын газар хамтран төрийн албан хаагчдын чадавхжуулах сургалтыг зохион байгуулж хэлтсийн 2 албан хаагч хамрагдсан.

Аймгийн орон нутгийн өмчийн газраас 2026 оны 05 дугаар сарын 25-ны өдөр Монгол улсын Засгийн газрын 2025 оны 238 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2026 оны 143 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд "Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогын арга зүй" сургалтыг зохион байгуулсан бөгөөд тус хэлтсээс хэлтсийн дарга, захиргааны ахлах мэргэжилтэн, ерөнхий нягтлан бодогч, нярав, хэлтсийн өмч хамгаалах байнгын зөвлөлийн нийт 8 албан хаагч танхимаар тус сургалтад хамрагдсан.

Төрийн албаны зөвлөлөөс улирал бүр зохион байгуулдаг Төрийн албаны ерөнхий болон тусгай шалгалтыг аймгийн Засаг даргын тамгын газартай хамтран шалгалтад бүртгүүлсэн

иргэдийг нягтлан шалгаж, хурууны хээг уншуулан программд бүртгэн оруулж хамтран ажиллаж байна.

Төрийн албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Улсын бүртгэлийн хэлтсийн албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоонд хамруулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулж эхний ээлжид хэлтсийн 20 ажилтныг Аймгийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран баталсан хуваарийн дагуу нарийн мэргэжлийн эмчийн үзлэг хамруулж үлдсэн 24 албан хаагчийг дараагийн ээлжийн хуваарийн дагуу үзлэг, шинжилгээнд хамруулахаар бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.

Мөн Төрийн албаны зөвлөлийн 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 521 дүгээр тогтоолоор Төрийн албан хаагчийн хувийн хэрэг хөтлөх журам шинэчлэн батлагдаж хувийн хэргийн бүрдэлд 2.1.11 дэх заалт Сэтгэцийн эрүүл мэндийн дүгнэлт нэмэгдсэн тул албан хаагчдыг аймгийн нэгдсэн эмнэлгийн сэтгэцийн эмчийн үзлэг оношилгоонд нэмэлтээр 20 албан хаагчийг хамруулан дүгнэлт авч үлдсэн албан хаагчдыг хамруулахаар ажиллаж байна.

ЗАВХАН АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТЭС